

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
“АЛСЫН ХАРАА – 2050” УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2025 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэг-жилтийн хувь
Нэг. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ							
1	1.1.Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна.	1.1.10.Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг хамгаалж, газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэнэ.	2020 - 2050			Үнэ цэн бүхий археологийн дурсгалт газрыг аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх үнэлгээ хийж, дурсгалт газруудыг хамгаалж, газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгүүлэх хүсэлт холбогдох газруудаас ирээгүй байна. Мэдээлэл ирсэн тохиолдолд газрын харилцааны мэдээллийн кадастрын санд бүртгэх боломж бүрэн хангагдсан. - Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем”-ийг улсын хэмжээнд нэвтрүүлэхээр шийдвэрлэж, системийн үнэн зөв, найдвартай ажиллагааг хангах зорилгоор тус системд холбогдож ажиллахыг холбогдох төрийн байгууллагууд болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон. Үүний дагуу ЗГХЭГ-ын даргын 2023 оны 107 дугаар тушаалаар тус асуудлыг шийдвэрлэх санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсгээс “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” тогтоолын хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөг батлуулж, санал боловсруулан, ЗГХЭГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн ХЭГ/265 дугаар албан тоотоор системд холбогдох шаардлагатай 16 байгууллагад хүргүүлсэн. Мөн ажлын хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Соёлын яамны төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, яамны орон зайн мэдээллийн систем болон ГНСУНЦС-тэй харилцан мэдээлэл солилцох шийдлээ тохиролцсон.	70

						Соёл, спорт аялал жуулчлалын яамны цахим системийн хөгжүүлэлтийн ажил 90 хувьтай, өгөгдөл, мэдээлэл бүрэн бүрдээгүй мэдээллийн үзүүлэлтүүд хангалтгүй, соёлын биет өвийн хамгаалалтын зурвасыг тогтоох тухай шийдвэр гараагүй байна. Дээрх ажлууд хийгдсэний дараа дундын мэлээллийн сангаар дамжуулан мэдээлэл солилцох боломжтой болох юм.	
Гурав. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА							
2	3.6.Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.	3.6.1.Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	2020 - 2050			Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 181 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын хууль, тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн хавсралтын 3,5,6,7,10 дугаар заалтуудад тусгагдсан байна. Үүнд дараах ажлуудыг хийж гүйцтгэж байна. ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны А/148 Тушаалаар Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. ГЗБГЗЗЕГ-ын 2025 оны А/145 тушаалаар Газрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалтын төсөл, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Уг ажлын хэсгийн хүрээнд Газрын тухай хууль, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудын хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, хуулиудийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо зэргийг их, дээд сургуулийн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн зөвлөх багаар гүйцэтгүүлэн 2025 оны 10 сард ажлын хэсэг болон Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээж авсан. Мөн тус хуулиудын үзэл баримтлалын төслийг боловсруулан ГЗБГЗЗЕГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн 2 удаагийн хурлаар хэлэлцүүлээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын өргөтгөсөн хурал, Хангайн бүс, Говийн бүсийн зөвлөлийн анхдугаар хурал, орон нутгийн удирдлагуудтай хийсэн цахим уулзалтууд, иргэд олон нийтээс гарсан саналууд болон	70

					орон нутагт нэн тэргүүнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үүднээс “Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулсан бөгөөд тус хуулийн төсөлд санал авахаар 21 аймгийн ГХБХБГ, Нийслэл, дүүргийн ГЗБА-ны удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, газрын даамлууд, нийт 100 гаруй төлөөлөл оролцсон цахим хэлэлцүүлгийг 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан.Тус хуулийн төсөлд олон нийтээс санал авахаар https://gazar.gov.mn/transparency/legal-framework/post/66348920 цахим хуудсанд байршуулж зохион байгуулан ажиллаж байна. ГЗБГЗЗЕГ-ын даргын 2025 оны А/229 дүгээр тушаалаар Кадастрын тухай хуулийн төслийн үзэл баримтлалтын төсөл, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлыг тооцоог шинэчлэн боловсруулахаар Монголын Кадастрын холбоотой 2025 оны 2025/117 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан ажилласан. Ажлын хэсэг нь зөвлөхөөс өгсөн зөвлөмжийн дагуу хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, мөн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан ГЗБГЗЗЕГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хурлаас гаргасан шийдвэрийн дагуу хуулийн төсөлд олон нийтээс санал авах ажлыг https://old.gazar.gov.mn/legacy/get-feedback-on-draft-law/8956438 цахим хуудсанд байршуулж зохион байгуулан ажиллаж байна. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн үзэл баримтлалын төслийг 5 бүлэг, 21 зүйлтэйгээр боловсруулан 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 1/3145 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох тооцоо, судалгааны хамт хүргүүлсэн. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн	
--	--	--	--	--	--	--

					A/368 дугаар тушаалаар Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 2 удаагийн хурал зохион байгуулж, хуулийн төсөлд холбогдох саналыг тусгасан. Тус хуулийн төсөлд 2025 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс иргэд, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. https://www.gazar.gov.mn/transparency/legal- Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Хаягжуулалтын тухай хуулийн үзэл баримтлалын төслийг дахин батлуулахаар 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1/2475 дугаар албан бичгээр Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайд, Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайд нараар баталгаажуулсан бөгөөд одоо Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар тус яаманд хүргүүлээд байна. Энэхүү үзэл баримтлалын дагуу Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 6 бүлэг, 17 зүйл, 55 хэсэг, 120 заалттайгаар боловсруулсан. Хаягжуулалтын тухай хуулийн төслийг байгууллагын веб хуудаст 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр (https://old.gazar.gov.mn/legacy/tsanal/hayagzhuulaltyn-tuhaj-huulijn-shinechilsen-najruulgyn-t-s-ld-sanal-avch-bajna) болон 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр (https://old.gazar.gov.mn/legacy/get-feedback-on-draft-law/6597348) байршуулж олон нийтийн санал авсан. Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, УБЕГ, Нийслэлийн хот байгуулалт, хотын	
--	--	--	--	--	--	--

						стандартын газар зэрэг 9 төрийн байгууллагаас авсан саналыг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан.	
3		3.6.2.Мэдлэгт суурилсан, иргэд, олон нийтийн оролцоотой газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлтийн системийг бий болгоно.	2020 - 2050			Газрын тохиромжтой болон хэрэгцээт байдлын үнэлгээ, газар зохион байгуулалтын төлөвлөлт, хяналтын системийн ТЭЗҮ-ийг 2020 онд Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Уг техник үндэслэлийн дагуу газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй холбоотой 13 төрлийн аргачлалыг боловсруулах, эдгээр аргачлалын дагуу систем хөгжүүлэлтийг хийхээр тусгасан. Уг ажлын гүйцэтгэхэд шаардлагатай зардлыг улсын төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн боловч төсөвт суугдаагүй тул ажлыг тогтвортой үргэлжлүүлэх зорилгоор ТЭЗҮ-д багтсан ажлуудыг хэсэгчлэн үе шаттайгаар санхүүжилтийн өөр эх үүсвэрүүдийг ашиглан гүйцэтгэж дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд: 1.ГЗБГЗЗЕГ-ын даргын 2024 оны А/305 дугаар тушаалаар "Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний аргачлал", мөн тус газрын даргын 2025 оны А/370 дугаар тушаалаар "Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал", 2025 оны А/369 дүгээр тушаалаар "Хадлангийн газрын тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг" тус тус боловсруулж, батлуулсан. 2.Газар зохион байгуулалтын хот төлөвлөлтийн цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах ажлын даалгаврыг боловсруулж 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн АД/2025-25 дугаартай батлуулсан. Мөн байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог газрын даргын А/100 дугаар тушаалаар байгуулж 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдөр худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан зарлаж гүйцэтгэгчээр "Софт мастер" ХХК шалгарч 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 2025/71 дугаартай гэрээ байгуулан, хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэж 11 дүгээр сарын 20-ны	100

					өдрийн ДДЗХ-ын шийдвэрийн дагуу №2025/ГБ33/56 дугаартай актаар эцсийн байдлаар хүлээн авсан. 3.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих, хэрэгжилтийг олон нийтэд ил тод мэдээлэх дашбоардыг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), НҮБ-ын ХХААБ-аас Хэрэгжүүлж буй "STREAM" төслийн дэмжлэгтэйгээр хөгжүүлж 2025 оны 06 сард ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлсэн (https://egazar.gov.mn/nature/dashboard/plan/chart/index). 4.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг харгалзах, тохиромжтой байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг цахимжуулах, хяналт тавих, биологийн олон янз байдлын мэдээллийг иргэд олон нийтэд нээлттэй үйлчлэх дашбоардыг Даян дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгтэйгээр хөгжүүлж 2025 онд ашиглалтад оруулж хэрэглээнд нэвтрүүлсэн (https://egazar.gov.mn/nature/dashboard/biology). 5.Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хяналт тавих зорилго бүхий газар ашиглалтын дэглэм, горим бүхий, зам шугам, сүлжээ, усны сан бүхий газар гэх мэт газруудын хамгаалалтын бүсийн мэдээллийн сан үүсгэх модуль, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хяналт тавьж, цахимаар дүгнэлт гаргах модуль, газрыг улсын тусгай хэрэгцээнд авах үйл ажиллагааг цахимжуулах модулуудыг газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим системд хөгжүүлэх ажлыг урсгал төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж 2025 оны 6-11 саруудад үе шаттайгаар хэрэглээнд нэвтрүүлсэн. 6.ТЭЗҮ-д орсон нэг гол ажил болох системийн хүчин чадлыг сайжруулах зорилгоор Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийн үйл ажиллагааг Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийн үйл ажиллагаанаас салгаж бие даасан байдалд шилжүүлэх ажлыг “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн өгөгдлийн санг шинэчлэн зохион байгуулах, бие даасан байдалд шилжүүлэх” ажлын хүрээнд гүйцэтгэж, хадгалах төхөөрөмж/storage/, физик серверүүдийн худалдан авалт хийж, системийн	
--	--	--	--	--	---	--

						бие даасан, хэвийн ажиллагааг хангаж 2025 оны 11 дүгээр сард хүлээн авсан. Хэрэгжилтийг өссөн дүнгээр авч үзвэл ТЭЗҮ-ийн хүрээнд шинээр боловсруулах 13 аргачлалын 4-ийг нь боловсруулж батлуулсан, 1 аргачлалыг боловсруулж дууссан. Системийн хөгжүүлэлтийн хэрэгжилтийн хувьд төлөвлөлтөд хяналт тавих, тохиромжтой байдлын үнэлгээ хийхэд шаардагдах шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийг олон нийтэд ил тод мэдээлэх зэрэг гэх мэт модулуудыг хэсэгчлэн хөгжүүлж цахимжуулсан зэрэг ажлуудаас үзэхэд нийт ажлын 40 хувь буюу өссөн дүнгээр газар зохион байгуулалтын үйл ажиллагааны 70 хувьтай тэнцэх ажлыг цахимжуулсан байна. Мөн системийн хөгжүүлэлтийг хийх бэлтгэл ажлыг хангах, суурь техник хангамжийг бий болгохтой холбоотойгоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дата төвийн хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлэхэд 2025 оны улсын төсөвт 1.1 тэрбум төгрөгийн зардлыг шийдвэрлэж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.	
4		3.6.3.Газрын кадастрын нэгдсэн ухаалаг систем байгуулж, иргэн төвтэй төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	2020 - 2050		КХ Бумаа	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Цахим системийг хэрэглээнд нэвтрүүлснээр аймаг, нийслэлийн Засаг дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газар, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, Чөлөөт бүсийн захиргаадаас газрыг иргэн, хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах үйл ажиллагааг Газрын кадастрын цахим системээр дамжуулан хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх боломжийг бүрдүүлсэн. Мөн ЗГХЭГ-ын даргын 2023 оны 107 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, Газрын кадастрын нэгдсэн цахим системийг ТЕГ, УБЕГ, ШШГГ, УБЗАА, УСУГ зэрэг 16 байгууллагатай дундын мэдээллийн сан байгуулан холбох ажлыг хэрэгжүүлэн төрийн байгууллагуудыг бодит цаг хугацаанд газрын харилцаатай холбоотой нэгдсэн мэдээллээр хангаж ажиллаж байна.	100

					Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем www.egazar.gov.mn, e-gazar гар утасны аппликэйшныг хэрэглээнд нэвтрүүлэн иргэд газрын харилцааны 27 нэр төрлийн үйлчилгээг цахим хэлбэрээр иргэн, хуулийн этгээдэд хүргэх боломж бүрдсэн. Мөн дээрх цахим үйлчилгээнүүдийг газрын харилцааны цахим киоск төхөөрөмж, төрийн үйлчилгээний e-mongolia платформуудтай холбож үйлчилгээ, мэдээлэл, лавлагаагаар үйлчилж байна. Газрын тухай хуулийн 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөд иргэний гэр бүлийн хэрэгцээнд үнэ төлбөргүй шинээр газар эзэмших хүсэлтийг цахимаар хүлээн авахаар тусгасан. Хуулийн хэрэгжилтийг хангуулж, Газрын удирдлагын нэгдсэн цахим систем egazar.gov.mn-ээр дамжуулан 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн нийт 101829 хүсэлтийг хүлээн авч, 5169 иргэн хүсэлтээ баталгаажуулсанаас 4795 иргэнд цахимаар гэр бүлийн хэрэгцээний газрыг үнэгүй эзэмшүүлээд байна. EGAZAR Гар утасны аппликейшны хөгжүүлэлтийн ажлын хүрээнд иргэн өөрийн газартай холбоотой 27 төрлийн хүсэлтээ гар утсаа ашиглан илгээх, эзэмшиж, ашиглаж, өмчилж байгаа газрынхаа байршлыг газрын зургаар харах, газрын татвар төлбөрөө төлөх, лавлагаа тодорхойлолт авах, кадастрын зураг, газрын гэрээ, гэрчилгээ, захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудас татах, өөрийн газартай холбоотой цаг үеийн мэдэгдлүүдийг шууд утсаараа хүлээн авах боломжтой байдлаар шинэчилж, Egazar.gov.mn-тэй уялдан ажилладаг хувилбарыг хэрэглээнд нэвтрүүллээ. Ингэснээр иргэн, хуулийн этгээд газрын албанд очилгүйгээр газартай холбоотой үйлчилгээг гар утаснаасаа түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлсэн. 2025 оны байдлаар 7,232,841 иргэн, хуулийн этгээд үйлчилгээ үзүүлсэн бөгөөд дараах үр дүн гарсан. Үүнд: Цахим үйлчилгээний үр дүнд: ➤ Газрын гэрчилгээ 2.1 тэрбум ➤ Кадастрын зураг 1.2 тэрбум ➤ Лавлагаа мэдээлэл 317.1сая	
--	--	--	--	--	---	--

					➤ Барьцаа бүртгэл 440.9 сая ➤ Баримт бичгийн хуулбар 110.2сая ➤ Мэдээллийн санд бүртгэх 196.1сая Нийт 4 399 508 000 төгрөг хэмнэсэн.	
5	3.6.Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.	3.6.4.Улсын хэмжээнд газар ашиглалтын зориулалт бүрээр тооллого явуулж, зурагжуулж, мэдээллийн санд бүртгэнэ.	2020 - 2050		Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 29 дүгээр тушаалаар “Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах” ажлыг хэрэгжүүлэх эрхийг ГЗБГЗЗГ-т шилжүүлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зарчмыг баримтлан нууцын зэрэглэлтэйгээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага “Ланд овнер” ХХК, “Газар дэлхий” ХХК-уудтай гэрээ байгуулан, Монгол улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан тус ажлыг гүйцэтгүүлсэн. Уг ажлын хүрээнд Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангиллыг газар ашиглалтын зориулалт тус бүрээр тооллого хийж, зураглан, Газрын нэгдмэл сангийн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлж, газрын нэгдмэл санд орж буй өөрчлөлтийг тухай бүрт хяналт тавин ажиллах боломжтой болсон. Газрын нэгдэл сангийн ангилалд 2024 онд орсон өөрчлөлтийн талаар тайланг гарган Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар танилцуулсан. Газрын нэгдмэл сангийн 2024 оны тайлангийн дүнг 2023 оны дүнтэй харьцуулахад хөдөө аж ахуйн газар 17.1 мянган га-аар хасагдаж, хот тосгон, бусад суурины газар 14.7 мянган га, зам, шугам сүлжээний газар 2.0 мянган га, ойн сан бүхий газар 0.5 мян.га-аар тус тус нэмэгдсэн байна. Харин усны сан бүхий газарт өөрчлөлт ороогүй байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаас ирүүлсэн Төв, Дорнод, Дундговь, Хэнтий Дархан-Уул аймгуудын нийт 15 сумын 63,262.48 га атар газрыг тариалангийн газрын ангилалд шилжүүлэх саналын дагуу Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газарт хэлэлцүүлэхээр 2025 оны 1/818 дугаар албан бичгийг хүргүүлсэн.	100

					Газрын нэгдмэл сангийн цахим системээс улс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, судалгаа, шинжилгээ боловсруулахад шаардлагатай мэдээллийг тухай бүр гарган хүргүүлж байна.	
6		3.6.5. Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн системийг бий болгоно.	2020 - 2050		Газрын тухай хуулийн 33.1.2-т заасны дагуу иргэн хуулийн этгээдэд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагааг иргэд олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах зорилгоор Газрын биржийн цахим систем (www.mle.mn) -ийг хэрэглээнд нэвтрүүлсэн. Газрын биржийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангаж жил бүр тогтмол нэмэлт, хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын А/03 дугаартай тушаалаар Газрын биржийн цахим системийн (www.mle.mn)-ийн шинэчилсэн 3.0 хувилбарыг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн. Мөн “Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газрын сан бүрдүүлэх, газар хөгжүүлэлт хийх” ажлын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлж 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр БХБЯ-ны дэргэдэх ШУТТЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдэн техник, эдийн засгийн үндэслэл батлагдсан. Газрын биржийн цахим систем (www.mle.mn) –р дамжуулан иргэд олон нийтэд үйлчилж дараах үр дүн гарсан. Үүнд: ➤ Газар өмчлүүлж эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа 18754 нэгж талбар ➤ Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулалт 2088 нэгж талбар ➤ Газар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээ 108,155 тус тус байна. Газрын биржээс олсон жилийн дундаж орлого 23.4 тэрбум, 2020-2024 оны хооронд нийт орлого 117.04	100

						тэрбум төгрөгийг олж Улсын төсөвт төвлөрүүлээд байна.	
7		3.6.6. Олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтцийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг хэрэглэгчдэд түгээх цахим тогтолцоог бий болгоно.	2020 - 2050			Монгол Улс-ОХУ хоорондын Улсын хил шалгах геодези, байр зүйн зураглалын ажлын хүрээнд хойд хил дагуу 5 аймгийн (Баян-Өлгий, Ногооннуур, Увс аймгийн Тэс, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Хэнтий аймгийн Дадал, Дорнод аймгийн Дашбалбар) сумдад навигацийн хиймэл дагуулын GNSS-ийн станцын иж бүрдэл төхөөрөмжийг шинээр суурилуулахаар гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэгч компани 5 станцын иж бүрдэл тоног төхөөрөмжийг албан ёсны төлөөлөгчийн газарт захиалан, олон улсын ачаа тээвэрлэлтээр дамжуулан хүлээн авч ГЗБГЗЗЕГ-ын хэмжил зүйн лабораторид шалгуулсан. Станцын иж бүрдлийг баруун аймгаас буюу хөлдөлт гэсэлтийн улирал хурдацтай явагдах магадлалтай аймаг сумдаас эхлэн газар дээр нь суурилуулсан. Улсын хилийн дагуу дээрх байршилд шинээр суурилуулсан GNSS-ийн байнгын ажиллагаатай 5 станц дээр захиалагчийн техникийн хяналт хийх тушаалыг боловсруулан 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар Газрын даргаар батлуулж холбогдох удирдамжийн дагуу шинээр суурилуулсан 5-н станцыг шинээр байгуулсан. Монгол улс байрлалын сүлжээний дээд ангийн байнгын ажиллагаатай нийт 48-н станцтай байгуулсан сум суурин газарт байршил тодорхойлох навигацийн хиймэл дагуулын бодит агшны засвар дамжуулалтыг хэрэглэгчдэд түгээж байна. Өндрийн 1 дүгээр ангийн сүлжээний хэмжилт, боловсруулалт хийх (55 цэг), Геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн 1 дүгээр ангийн сүлжээтэй холбох хэмжилт хийх, Геодезийн сүлжээний эхлэл цэгийг өндрийн 1 дүгээр ангийн сүлжээтэй холбох хэмжилт хийх, Монгол Улсын өндрийн 1 дүгээр ангийн сүлжээний 2 дугаар гарын тэгшитгэн бодолтыг хийх ажлуудын үр дүнгээр өндрийн I ангийн сүлжээний цэгийн солбицол, өндрийн утгыг Газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/81 дугаар тушаалаар батлуулж, батлагдсан жагсаалтыг Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.	100

						Япон улсын Гео-орон зайн мэдээллийн агентлаг, ГЗБГЗЗЕГ хооронд хамтын ажиллагааны Санамж бичиг 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан. Япон улсын Гео-орон зайн мэдээллийн агентлагийн дэмжлэгтэйгээр абсолют гравиметрийн хэмжилтийг Монгол Улсын Гравиметрийн тулгуур сүлжээний 3 цэг дээр (УБ хот, Дорнод, Өмнөговь аймаг) 2024 оны III улиралд хийсэн. Энэхүү хэмжилт нь хүндийн хүчний хурдатгалын утгыг 40 жилийн дараа орчин үеийн хэмжлийн багаж ашиглан давтан тодорхойлсноор өндөр ач холбогдолтой юм. Гравиметрийн тулгуур сүлжээний 3 цэгийн хүндийн хүчний хурдатгалын утгыг 2024 оны А/367 дугаар тушаалаар батлан хэрэглээнд нэвтрүүлсэн.	
8	3.6. Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.	3.6.7.Монгол орны газар нутгийг бодит агшны мэдээлэл бүхий байр зүйн тоон зургаар зурагжуулж, хэрэглэгчдэд шуурхай хүргэж, хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн байр зүйн болон баталгаажсан нэг маягийн суурьтай сэдэвчилсэн газрын зураг, атласаар хангана.	2020 - 2050		ГЗЗХ	“Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах”, “Монгол орны өндрийн тулгуур сүлжээг шинэчлэх” ТЭЗҮ-ийг Барилга, хот байгуулалтын Дэд сайдаар батлуулсан. Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25000-ны масштабтай байр зүйн зургаар зурагжуулах ажлын саналыг 2020-2023 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний төсвийн төсөлд тусгуулахаар БХБС-ын албан тоотыг Сангийн яаманд хүргүүлсэн хөрөнгө тусгагдаагүй. 1:25000-ны масштабтай байр зүйн зургийг хийх ажлын үндэслэл, хэрэгцээ, шаардлага, төсвийн тооцоо гаргаж 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн н/21 дугаартай албан бичгээр ҮАБЗ-д хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1/2234 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв. 1:25000-ны масштабтай байр зүйн зургийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил, зам харилцаа, эрчим хүч, харилцаа холбооны шугам, суурин газар, уст цэгийн байрлал, зам, шугам сүлжээ, гол, нуур, ойн тархалт зэрэг агуулгаар тогтмол баяжуулан навигацийн систем хөгжүүлэх, тоон зурагт суурилсан мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сэдэвчилсэн газрын зураг, атлас зохиох зэрэг ажлын суурь болдог ач холбогдолтой.	70
9		3.6.8.Хот байгуулалт,	2020 - 2050			www.urban.gov.mn системээр дамжуулан геопортал цахим системийг хөгжүүлэлтээр том масштабын байр	100

		инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах, өргөтгөх, ашиглах үеийн геодезийн хэмжлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.			зүйн зураг оруулах болон тэг тэнхлэгийн мэдээллийг цахим системд оруулах хөгжүүлэлт хийгдсэн бөгөөд 21 аймгийн барилга байгууламж болон Говь-Алтай аймгийн Тонхил сумын ариутгах татуургын шугам хот байгуулалтын кадастрын цахим системд туршилт хийсэн. Улсын хэмжээнд барилга, инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх ажлын үйл ажиллагааг ЦАХИМЖУУЛЖ шийдвэрлэлтийн явцыг харах, хянах боломжтой болсон. Үүнд: ➤ Батлагдсан Архитектур төлөвлөлтийн даалгавар -822 ➤ Батлагдсан загвар зураг (эскиз) -213 ➤ Барилга, шугам сүлжээний ажлын зөвшөөрлийн гэрчилгээ -308 ➤ Бүртгэсэн байр зүй, тэг тэнхлэг /улаан шугам/ - 285 ➤ Баталсан барилга ашиглалтад оруулах комиссын дүгнэлт -72 тус тус байна. Цахим ситемд нийт 13194 хүсэлт ирсэнээс 8753 шийдвэрлэсэн байна.	
10		3.6.9.Газар, байгаль, эдийн засаг, нийгмийн нөөц, чадавхад тулгуурлан газар ашиглалт, хамгаалалтын үр ашгийг дээшлүүлэх, газрыг иргэд болон эдийн засгийн хувьд үндэслэл сайтай, үр ашигтай, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан газар зохион байгуулалтыг хөгжүүлж, газрын	2020 - 2050		2020 оноос хойш Нийслэл газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Орхон, Дорнод, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий, Ховд аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчилж, Дархан-Уул, Өмнөговь аймгуудын төлөвлөгөөг тодотгон боловсруулж, 20 аймгийн 181 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, 21 аймгийн 148 сумын төвийн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар Өвөрхангай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө шинэчлэн боловсруулагдаж, Говьсүмбэр, Дорноговь, Хөвсгөл аймгуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 12 аймгийн 79 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, 18 аймгийн 90 сумын төв хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байна. Энэ онд Засгийн газрын 2025 оны 120, 06, 74, 172 дугаар тогтоолуудаар улсын	100

		нөөцүүдийг оновчтой ашиглаж хэвшинэ.				хэмжээнд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлуулсан бөгөөд улсын хэмжээнд нийт 244.69 мянган га талбай бүхий 28882 байршилд газрыг эзэмшүүлж, ашиглуулахаар баталсан.	
11		3.6.10.Зайнаас тандан судлалын технологид суурилсан газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, нэвтрүүлнэ.	2020 - 2050			Газрын мониторингийн цахим системийг 2025 онд шинэчлэн хөгжүүлж, газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа, газарт учруулсан хохирол, нөхөн сэргээлт, бэлчээрийн төлөв байдлын статистик (дашбоард), зайнаас тандан судлалын модулийн нэмэлт хөгжүүлэлтүүдийг хийж, хиймэл дагуулын мэдээ (Mongolian data cube)-г мониторингийн орон зайн дүн шинжилгээнд холбож, газрын мониторингийн цахим системд зайнаас тандан судлал, өндөр нарийвчлал бүхий хиймэл дагуулын зураг ашиглан мониторинг хийх, бохирдол, доройтолд орсон байршлуудыг тодорхойлох, нөхөн сэргээх үйл ажиллагааг цахимжуулж, egazar.gov.mn цахим хуудсаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэж байна. Мөн бэлчээрийн фото мониторингийн хээрийн судалгааг хийх гар утасны “Belcheer” аппликейшнийг хөгжүүлж, хэрэглээнд гаргасан. Газрын мониторингийн цахим системд итгэмжлэгдсэн лабораториудыг холбож, газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын хөрс, усны шинжилгээний мэдээллийг оруулах ажлыг цахимжуулсан. Мониторингийн чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлдэг байгууллагуудын мэдээллийг дундын мэдээллийн санд оруулж, хэрэглэгчдэд харах боломжтой байдлаар хөгжүүлсэн. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан, дүгнэлтийг 2021-2025 оны хооронд 84,400 нэгж талбарыг газрын мониторингийн цахим системээр хүлээн авч, баталгаажуулсан. Газрын мониторингийн сүлжээний цэгт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг 2021-2025 онд нийт 2550 мониторингийн цэгт зохион байгуулж, газрын төлөв байдал, чанар, хөрсний элэгдэл, эвдрэл, доройтлыг тодорхойж, газрын мониторингийн үндэсний сүлжээний мэдээллийг санг баяжуулсан.	100

12	3.6. Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.	3.6.11. Гурав ба дөрвөн хэмжээст газрын кадастрын нэгдсэн системийг бий болгож хөгжүүлнэ.	2020 - 2050			Монгол улсын хэмжээнд 1,710,964 өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүсэн нэгж талбар бүхий газар бүртгэлтэй байгаа бөгөөд эдгээр газартай холбоотой 2D хэмжээст улсын бүртгэлийн харилцааг эрхлэн явуулж байна. “Улсын хэмжээнд 3D, 4D (хэмжээст) кадастрын мэдээллийн нэгдсэн системийг байгуулах, хэрэглээнд нэвтрүүлэх” ажлын техник, эдийн засгийн үндэслэл” боловсруулах ажлын 2021/91 тоот даалгаврыг Барилга хот байгуулалтын яамны ТНБД-аар батлуулан, 2022.04.01-ний өдрийн 2022/96 тоот зөвлөх үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан. Уг гэрээт ажлын тайланг ГЗБГЗЗЕГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, ГЗБГЗЗЕГ-ын дэргэдэх салбарын орон тооны мэргэжлийн зөвлөлийн хурал, БХБЯ-ны Шинжлэх ухаан, техник, технологийн хурлаар хэлэлцүүлэн 2022 оны 11 дүгээр сард батлуулсан. Мөн тус ТЭЗҮ-ийг үндэслэн “Гурав болон дөрвөн хэмжээст кадастрын бүртгэл хийх аргачлал”-ын төсөлд 3 хэмжээст кадастрын бүртгэл хийх технологийн аргачлал, арга зүйн талаар тусгаж, Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлаас гарсан шийдвэрийн дагуу Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан.	70
13		3.6.12.Хиймэл оюун ухаан болон блокчейн технологид суурилсан газрын үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг бий болгоно.	2020 - 2050			Газар зүйн мэдээллийн системд суурилсан Газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрын суурь үнэлгээг газрын зах зээлийн үнийн мэдээнд үндэслэн газрын үнэлгээнд нөлөөлөх хүчин зүйлсийн (Хүрээлэн буй орчны, инженерийн дэд бүтцийн, нийгмийн дэд бүтцийн) утгыг тооцож тухайн газрын суурь үнэлгээг автоматаар тооцох боломжтой газрын үнэлгээний (САМА) цахим систем болон газрын төлбөр, татвар тооцож, ногдуулах, төлбөрийн нэхэмжлэх үүсгэх, улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн ногдуулалт үүсгэх хяналт тавих газрын төлбөр, татварын цахим системийг хэрэглээнд нэвтрүүлсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар газрын үнэлгээний цахим систем ашиглан улсын хэмжээнд хот, тосгон, бусад суурин газрын нийт 39795 нэгж талбарын газрын зах зээлийн үнийн мэдээг боловсруулан үр дүнг ашиглан 1522868 нэгж талбарт масс үнэлгээ бодуулж,	100

						газрын үнэлгээний бүсчлэл болон 1 га газрын суурь үнийг боловсруулсан. Мөн газрын төлбөр, татварын цахим системээр 2021-2025 оны хооронд 602.7 тэрбум төгрөгийн ногдуулалт үүсгэж, 513.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.	
14		3.6.13. Дэвшилтэт технологид суурилсан гурван хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн системийг хөгжүүлнэ.	2020 - 2050			Кадастрын мэдээллийн нэгдсэн системийг өргөжүүлэн, газар болон түүн дээр байрлах аливаа үл хөдлөх эд хөрөнгийн бодит зураглал, бүртгэл, мэдээлэл 3D (хэмжээст) байдлаар бүрдүүлэх, үл хөдлөх эд хөрөнгийн цогц мэдээлэл бүхий нэгдсэн гурван хэмжээст бүртгэл бий болгох зорилгоор хот байгуулалтын кадастрын систем, хаягийн мэдээллийн системтэй холбож дундын мэдээллийн сан байгуулсан. Одоогийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газар гэсэн 2 байгууллагуудтай харилцан мэдээллээ тухай бүр солилцож, нийт 500,000 барилгын бүртгэлийг нэгтгэж, 2D хэмжээст Газар болон үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн санг үүсгээд байна.	100
15		3.6.14. Улсын хэмжээнд гурван хэмжээст байр зүйн болон газар доорх инженерийн шугам сүлжээний зургийг зохионо.	2020 - 2050			2022 онд “Хэнтий аймгийн Хэрлэн сумын төвийн барилгажсан хэсгийн 3D зураглалд зориулсан агаарын зураг авах, боловсруулах” ажлын даалгавар боловсруулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан гүйцэтгэгч “Спэйшл моделинг” ХХК-тай гэрээ байгуулж 320 га талбайд 5500 орчим зураг (дээрээс, хойноос, урдаас, баруунаас, зүүнээс чиглэлд) авч, гүйцэтгэлийг ГЗЗХ/2022/50 дугаар дүгнэлтээр Геодези, зураг зүйн мэдээллийн санд хүлээлгэн өгсөн. 21 аймгийн барилга байгууламж болон Говь-Алтай аймгийн Тонхил сумын ариутгах татуургын шугам хот байгуулалтын кадастрын цахим системд туршилт хийсэн. 2024 оны 2024/03 дугаартай “Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох” 153283 га талбайд ажлын даалгавар батлагдаж, НХААГ/20240103238 дугаартай гэрээт ажлыг “Геосан” ХХК, “Геокад” ХХК-ийн түншлэл, туслан гүйцэтгэгчээр “Монмэп” ХХК гүйцэтгэсэн. Захиалагчийн техникийн хяналт хийх 2024/359 дугаартай гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч “Геосан” ХХК 2025 оны 09 дугаар сарын 26-	100

					ны өдрийн 02/519 дугаар бичгээр гэрээ сунгах хүсэлтээ ирүүлж, 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 2025/127 дугаар гэрээгээр захиалагчийн хяналт хийх гэрээг сунгасан. 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Геосан” ХХК-аас ирсэн 02/607 дугаар албан бичгийн дагуу Улаанбаатар хотын ортофото зураг, өндрийн тоон загварыг хүлээн авсан. Үүний дагуу А/232 дугаар тушаалын дагуу “Агаарын зураг, ортофото зураг, газрын гадаргын тоон загварт хяналт” хийх 2025/АД/72 дугаар ажлын даалгавар батлуулж, гүйцэтгэгчтэй 2025/145 дугаар гэрээ байгуулан захиалагчийн техникийн хяналт хийж гүйцэтгэсэн. 2024 онд Өмнөговь аймгийн 4 сумын 1:1000-ны масштабтай байр зүйн болон инженерийн шугам сүлжээний зураглалыг ITRF2020 солбицлын тогтолцоонд гүйцэтгэх ажлын даалгавар батлагдаж, “Агар од инженеринг” ХХК гүйцэтгэсэн. Өмнөговь аймгийн Ханбогд, Даланзадгад, Гурвантэс, Цогтцэций сумын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох ажлын эцсийн тайланг шалгаж 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 2025/36 дугаартай дүгнэлт гаргаж, актаар Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгөв. 2025 оны АД/2025-34 дугаартай “Дорноговь аймгийн Сайншанд, Сайхандулаан сум, Орхон аймгийн Баян-Өндөр сумдад “1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох” ажлын даалгаврыг батлуулж хүргүүлэв.	
16		3.6.15.Геодезийн олон улсын маш урт суурь талтай интерферометрийн (VLBI) станц байгуулна.	2020 - 2050		“Монгол Улсад хэт урт суурь шугам тооцоолох станц (VLBI) байгуулах” ажлын даалгавар боловсруулж Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж БХБЯ-аар батлуулахаар 2023 оны 05 сарын 26-ны өдөр 1/1128 дугаар албан бичгээр ажлын даалгаврыг хүргүүлсэн. 2023 оны 06 сарын 21-ний өдрийн БХБЯ-ны Шинжлэх ухаан, техник, технологийн хурлаар хэлэлцүүлэн, шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжилтийг шийдэх боломжгүй гэж шийдвэрлэсэн. Ажлын даалгаврыг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 1/703 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэн батлуулсан.	30

					Геодезийн маш урт суурь талтай интерферометрийн (VLBI) станц байгуулах техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын төсвийг 2026 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусгуулахаар 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1/2234 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Геодезийн маш урт суурь талтай интерферометрийн (VLBI) станц байгуулснаар дэлхийн гадаргуу дээрх объектын байрлалыг орчлон ертөнцийн хэмжээнд нарийвчлалтай тодорхойлох боломжийг бүрдүүлэн, дэлхий, нар сар, од гариг, галактик бүгд өөр өөр хурдаар хөдөлж байхад эдгээр хөдөлгөөнөөс үл хамааран дэлхий дээрх байрлалыг өндөр нарийвчлалаар тодорхойлох, төв азийн хавтанг судлах маш том азийн судалгааны төвтэй болох ач холбогдолтой.	
17		3.6.16. Байрлалд суурилсан орон зайн мэдээллийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	2020 - 2050		Орон зайн өгөгдөл, мэдээллийг боловсруулах, солилцох, түгээх, үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд дэд бүтэц байгуулах асуудал нь өөр хоорондоо харилцан уялдаатай 3 хэсгээс бүрдэнэ. 1-р хэсэгт Өгөгдлийн хүрээ, 2-р хэсэгт Өгөгдөлийн стандарт (байрлалд суурилсан орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, түгээхэд шаардагдах салбар хоорондын зохицуулалт бүхий өгөгдлийн стандартыг боловсруулж, батлуулсан). 3-р хэсэгт Арга хэмжээний төлөвлөгөө (ҮОЗДБ-ийг байгуулахад шаардлагатай арга хэмжээнүүд, үндэсний хэрэгцээ, тэргүүлэх чиглэлд тусгайлан зориулсан төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан). НҮБ-ын Дэлхийн Орон зайн мэдээллийн менежментийн Зөвлөхүүдийн хорооны 2018 оны 08 дугаар сард АНУ-ын Нью Йорк хот дахь НҮБ-ын төв байранд болсон VIII хурлаас улс орнуудын боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийг бий болгох заавар бүхий Орон зайн мэдээллийн нэгдсэн хүрээ (Integrated Geospatial Information Framework)-г баталсан.	70

					Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн өгөгдлийн санг бие даасан байдалд шилжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Худалдан авах ажиллагааны газартай хамтран зохион байгуулж байна. Мөн Монгол Улсын хэмжээнд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийг төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбож өгөгдөл, мэдээлэл солилцох “Дундын мэдээллийн сан”-г хэрэглээнд нэвтрүүлсэн. Дундын мэдээллийн санд 4 байгууллагын 9 систем холбогдсон. Нийт газрын харилцааны 20 үйлчилгээг төрийн байгууллагуудад үзүүлж байна.	
18		3.6.17. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг нутагшуулж, байгаль, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн үр дүнтэй газрын удирдлага, менежментийг хэрэгжүүлэх инновац ба түншлэлийг бий болгоно.	2020 - 2050		- ISO 19157 Газарзүйн мэдээлэл-Өгөгдлийн чанар стандартыг орчуулан, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. - ISO 19119:2016 Газарзүйн мэдээлэл-Үйлчилгээ, ISO 19115 Газар зүйн мэдээлэл-Метадата стандартыг орчуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. - MNS 6925 1:18 Газарзүйн мэдээлэл-Өгөгдөл техникийн үзүүлэлт стандартын дагуу бусад байгууллагын мэдээллийн санг хөрвүүлэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. Орон зайн өгөгдлийн цахим системд бусад байгууллагын мэдээллийн санг холбох-дундын мэдээллийн санг бий болгох хүрээнд: Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж ЗГ-ын 2025 оны 03 дугаар сарын 06 өдрийн 121 дүгээр тогтоолоор батлуулсан бөгөөд салбар “Дундын мэдээллийн сан”-г төвлөрүүлэхээр ажиллаж байна. Үүнд: ➤ Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Байгаль орчны мэдээллийн төрөлжсөн болон гео мэдээллийн сангийн мэдээ, мэдээлэл ➤ Зам, тээврийн хөгжлийн яамаас Зам,замын зурвас газар, тээвэр, холбооны зурган болон бүртгэлийн мэдээлэлийг нэгтгэх	100

						➤ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Уул, уурхайн ашиглалт болон хайгуулын талбайн зурган болон бүртгэлийг мэдээлэл төрөл бүрээр нэгтгэх ➤ Эрчим хүчний яамнаас Инженерийн шугам сүлжээний зурган болон бүртгэлийг мэдээллийг төрөл бүрээр нэгтгэх ➤ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Бэлчээр, тариалан газрын, мониторингийн цэгийн зурган болон бүртгэлийн мэдээллийг нэгтгэх ➤ Статистикийн ерөнхий газраас Малын тоо толгойн мэдээлэл, малчин өрхийн мэдээллийг төрөл бүрээр нэгтгэх ➤ Улсын бүртгэлийн ерөнхий газраас Газар өмчлөлийн шилжилт хөдөлгөөн, иргэн, хуулийн этгээдийн бүртгэл болон үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийг нэгтгэх ➤ Цаг уур, орчны шинжилгээний газраас Ус, цаг уур, уур амьсгал, байгаль орчны судалгааны бодит, урьдчилсан мэдээ, мониторингийн цэгийн зурган болон бүртгэлийн мэдээллийг нэгтгэх Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж хамтран ажиллах гэрээг байгуулсан.	
Тав. ЗАСАГЛАЛ							
19	5.3.Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ.	5.3.7.Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж шийдвэр гаргах бүх түвшинд ашиглана.	2020 - 2050			- Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан. - “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж ЗГ-ын 2025 оны 03 дугаар сарын 06 өдрийн 121 дүгээр тогтоолоор батлуулсан. Стандартын техникийн шаардлагуудыг Европын холбооны хүрээлэн буй орчинд нөлөөлөх бодлого, үйл ажиллагааг зохицуулах орон зайн өгөгдлийн дэд бүтэц болох INSPIRE системийн баримт бичиг, ISO 19100 бүхий цуврал стандартуудын шаардлагад тулгуурлаж, Монгол орны Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн салбарт мөрдөж буй норм, дүрэм журам, байр зүйн	100

						зургийн суурь орон зайн өгөгдлийн бүтэц, агуулга, ангиллыг үндэслэн MNS:6925 1-18:2021 Газарзүйн мэдээллийн цуврал стандарт, MNS ISO 19131:2022 Газарзүйн мэдээлэл-Өгөгдөл, техникийн үзүүлэлт стандартыг боловсруулж, батлуулсан.	
20		5.3.8.Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.	2020 - 2050			2020-2022 онд “Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн систем байгуулах” ажлын хүрээнд хаягийн өгөгдөл мэдээллийг засварлаж, 21 аймгийн 330 сумын хэмжээнд хаягийн мэдээллийн системийг хаягжуулах үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Засгийн газрын 2022 оны 180 дугаар “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” тогтоолын дагуу 21 аймгийн 330 сумын хэмжээнд Хаягийн мэдээллийн системийг нэвтрүүлэн шинэчилсэн хаяг олгосон. Хаягийн мэдээллийн системд 21 аймгийн 330 сумын хэмжээнд 50530 гудамж, зам, 689,888 барилга, 1139127 нэгж талбар, 258,650 газар, усны нэр, 628,436 орц, гарцын мэдээллийг оруулж тус тус хаяг олгоод байна. 2023 оноос нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд гудамж, зам, талбай, орц, гарцыг зураглаж хаягийн орон зайн өгөгдөл мэдээллийг бүрдүүлсэн. Нийслэлийн хэмжээнд 41598 гудамж, зам, 318510 барилга, 516963 нэгж талбарт тус тус хаяг олгоод байна. 2024 онд “Хаягийн мэдээллийн системийн нэмэлт хөгжүүлэлт” хийх ажлын хүрээнд хаягийн мэдээллийн системийг боловсронгуй болгож, хаяг олгох үйл ажиллагааг бүрэн автоматжуулах, цахимжуулах, нээлттэй веб-д суурилж хөгжүүлсэн. 2025 онд “Хаягийн мэдээллийн систем”-д нэмэлт хөгжүүлэлт хийгдсэн шинэ системийг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумдад хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Үүнд: Олон улсын жишигт нийцсэн хаягийн удирдлагын системийн сургалтыг нийслэл, 9 дүүргийн Газар зохион байгуулалтын албаны холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, Чингэлтэй дүүргийн хэмжээнд, 2025 оны 08 дугаар сарын 22-ний өдөр Хүннү хотын Захирагчийн ажлын алба, Сүхбаатар дүүргийн ГЗБА-ны	100

						мэргэжилтэнүүдэд, 2025 оны 09 сарын 09 ны өдөр Баянгол, Хан-Уул дүүргийн ГЗБА-ны мэргэжилтэнүүдэд сургалтыг тус тус зохион байгуулж, хаягийн мэдээллийн системийг хэрэглээнд нэвтрүүлээд байна. Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яам мөн Газар геоматик корпорацтай хаягийн талаар харилцан мэдээлэл солилцох хамтран ажиллах санамж бичгүүдийг байгуулсан. БНСУ-тай байгуулсан санамж бичгийн хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-ын санхүүгийн дэмжлэгт тулгуурлан “Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх” төслийг 2026-2029 оны хооронд 8 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдэн, хамтран ажиллаж байна.	
Зургаа. НОГООН ХӨГЖИЛ							
21	6.2.Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.	6.2.13.Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.	2020 - 2050			- “Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөл”-ийн хүрээнд “Бэлчээрийн фото мониторингийн цэг төлөөлөх талбайг нарийвчлан зураглаж, газрын мониторингийн цахим системд оруулах” ажлын хүрээнд мониторингийн цэг төлөөлөх талбайн хэмжээ, бэлчээрийн төлөв байдал нь доройтсон газрыг зураглаж, газрын мониторингийн цахим системийн нөхөн сэргээх, хамгаалах цэсрүү илгээх, оруулах байдлаар хөгжүүлэлт хийгдсэн. Бэлчээрийн фото мониторингийн сэргэх чадавхын 3, 4, 5 дугаар түвшний цэгийн талбайг газрын хохирол, доройтол цэс рүү татах хөгжүүлэлтийг хийсэн. - “Газрын доройтол тодорхойлох аргачлал” болон “Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээх чиглэлээр олон улсын туршлага, дэвшилтэт шинэлэг технологийн аргачлалын судалгаа хийж, монгол улсад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх туршилтыг хийх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны аргачлал”-ын төслүүдийг боловсруулж, холбогдох хурлуудаар хэлэлцүүлсэн.	100

					- 2025 онд газрын мониторингийн цахим системд зайнаас тандан судлал, өндөр нарийвчлал бүхий хиймэл дагуулын зураг ашиглан мониторинг хийх, бохирдол, доройтолд орсон байршлуудыг тодорхойлох, нөхөн сэргээх үйл ажиллагааг цахимжуулж, тэдгээрт хяналт тавих хөгжүүлэлтийн ажлыг зохион байгуулж байна. - 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 18 аймагт 2,715,639.9 га талбай бүхий 653 байршилд газрыг нөхөн сэргээж, хамгаалахаар төлөвлөөд байна.	
22	6.2. Байгалийн нөөц баялгийг нөхөн сэргээж, хомсдолыг бууруулан ашиглалтын нөөц бий болгож, байгалийн үр өгөөжийг ирээдүй хойч үедээ өвлүүлнэ.	6.2.16.Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй болгоно.	2020 - 2050		Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системийг egazar.gov.mn сайтад хэрэглээнд нэвтрүүлж, 2023 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөө, газар олголтыг байршил, цаг хугацаа, эрх бүхий этгээдийн шийдвэрийн мэдээллийг олон нийтэд ил болгосон “ШИЛЭН ГАЗАР” цэсийг шинээр бий болгосон. Мөн Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим систем (egazar.gov.mn)-д бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний мэдээллийг бүртгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих 2 төрлийн дашбардыг нэвтрүүлсэн. Үүнд: ➤ Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний статистик ➤ Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахад биологийн олон янз байдал, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлыг харгалзах тус тус нэвтрүүлээд байна. 2025 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, түүнд хяналт, тавих, бүх шатны төлөвлөгөөний тайлан болон тоон мэдээллийг олон нийтэд нээлттэй татаж авах, ашиглах боломжтой хөгжүүлэлтийг хийсэн.	100